



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/391

Улаанбаатар хот

Түгээлтийн хуваарь батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дах хэсэг, Монгол Улсын Засгийн газар ба Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Хүүхдийн Сангийн хооронд 2003 онд байгуулсан “Худалдан авах үйл ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичиг”, Засгийн газрын 2015 оны 447 дугаар тогтоолоор батлагдсан “Хүн амын хоол тэжээл” үндэсний хөтөлбөрийн 4.2.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.1.7.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. НҮБ-ын Хүүхдийн сангийн төсөл хэрэгжүүлж байгаа аймаг, дүүргийн хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүдэд зориулсан олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэл түгээх хуваарийг нэгдүгээр, өндөр хэмжигч, жин түгээх хуваарийг хоёрдугаар, хоол тэжээлийн цочмог дутлын эмчилгээний бэлдмэл түгээх хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай

2. Хуваарийн дагуу түгээлт хийж, тайланг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвд ирүүлэхийг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт даалгасугай.

3. Хоол тэжээлийн дутал, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгааг иргэдийн дунд тасралтгүй зохион байгуулж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Д.Нарантуяа/-д даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн газар /Т.Энхзаяа/-т үүрэг болгосугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

081572


Эрүүл мэндийн сайдын
2018 оны 09 сарын 24 өдрийн
А/39/ дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

НҮБ-ЫН ХҮҮХДИЙН САНГИЙН ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЖ
БАЙГАА АЙМАГ, ДҮҮРГИЙН ХҮҮХЭД, ЖИРЭМСЭН ЭМЭГТЭЙЧҮҮДЭД
ЗОРИУЛСАН ОЛОН НАЙРЛАГАТ БИЧИЛ ТЭЖЭЭЛИЙН
БЭЛДМЭЛ ТҮГЭЭХ ХУВААРЬ

д/д	Аймаг/дүүргийн эрүүл мэндийн газар/төв	Хүүхдийн ОНБТБ		Жирэмсэн эмэгтэйд зориулсан ОНБТБ	
		Хүүхдийн тоо	ОНБТБ тоо, жигж хайрцаг	Жирэмсэн эмэгтэйн тоо	Бэлдмэлийн тоо, ширхэг
1	Баянхонгор	2,500	10 000	719	130
2	Говь-Алтай	1,500	6000	500	91
3	Завхан	2,143	8572	600	110
4	Баянзүрх дүүрэг	8,000	32 000	3000	535
5	Асрамжийн газруудад	1,000	4000	-	-
	Нийт	15,143	60,572	4,819	866

А/391


Эрүүл мэндийн сайдын
2018 оны 09 сарын 24 өдрийн
дугаар тушаалын 2 дугаар хавсралт



ӨНДӨР ХЭМЖИГЧ, ЖИН
ТҮГЭЭХ ХУВААРЬ

д/д	Аймаг/дүүргийн эрүүл мэндийн газар/төв	Өндөр хэмжигч, жингийн төрөл					
		Өндөр хэмжигч	Нярайн тавагтай жин	Электрон жин	Нярайн гар жин	Бандаж	Бугалга хэмжигч
1	Баянхонгор	28	-	50	20	11	24
2	Говь-Алтай	24	-	40	-	-	18
3	Завхан	20	3	50	-	-	21
4	Баянзүрх дүүрэг	-	-	-	-	-	25
5	Асрамжийн газруудад	5	-	5	8	2	5
	Нийт	77	3	145	28	13	93

Эрүүл мэндийн сайдын
2018 оны 09 сарын 24 өдрийн
А/39 дугаар тушаалын 3 дугаар хавсралт



ХООЛ ТЭЖЭЭЛИЙН ЦОЧМОГ ДУТЛЫН
ЭМЧИЛГЭЭНИЙ БЭЛДМЭЛ ТҮГЭЭХ ХУВААРЬ

д/д	Аймаг/дүүргийн эрүүл мэндийн газар/төв	S0000236 F-75 Эмчилгээний сүү, 400гр/ Хайрцгандаа 24 уут	S0000237 F-100 Эмчилгээний сүү, 400гр Хайрцгандаа 24 уут	Nutri Feedo Эмчилгээний нуhash 92гр/ Хайрцгандаа 150 ширхэг	S1561125 Рисомал, 42гр
1	Баянхонгор	1	10 уут	30	10
2	Говь-Алтай	1	7 уут	20	10
3	Завхан	1	7 уут	20	10
4	Баянзүрх дүүрэг	2	12 уут	50	20
5	Сонгинохайрхан	2	12 уут	50	20
6	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	3	1 хайрцаг	10	10
7	Нялхсын клиник сувилал	2	1 хайрцаг	5	5
8	Асрамжийн газруудад	-	-	4	5
	НИЙТ	12	4 хайрцаг	189	90

Тайлбар: Хоол тэжээлийн цочмог дутлын эмчилгээнд NutriFeedo-Эмчилгээний нухаш, F-75, F-100 сүүг "Хоол тэжээлийн цочмог дутлын цогц менежмент" зааврын дагуу эмнэлгийн ажилтаны хяналтан дор хэрэглэнэ.